



**ШҮҮГЧИЙГ ХУУЛИЙН ТӨСӨЛ
БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН
ХЭСЭГТ АЖИЛЛУУЛЖ БҮЙ
БАЙДАЛ**

ЛАВЛАГАА

**Шүүхийн ерөнхий
зөвлөлийн
гүйцэтгэх нарийн
бичгийн даргын
захиалгаар бэлтгэв.**

ШҮҮГЧИЙГ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГТ АЖИЛЛУУЛЖ БУЙ БАЙДАЛ /ЛАВЛАГАА/¹

Нэг. Удиртгал

2017.01.01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж буй Хууль тогтоомжийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-т “Хууль санаачлагч салбар хоорондын уялдааг хангах зорилгоор холбогдох байгууллагын удирдлагатай тохиролцож, тухайн асуудлыг хариуцсан мэргэжилтнийг хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажилд оролцуулж болно” гэж заасан. Үүнээс өмнө үйлчилж байсан Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг буюу хуулийн төсөл боловсруулах талаарх хууль санаачлагчийн бүрэн эрхэд байгууллагын удирдлагатай нь тохиролцсоны үндсэн дээр холбогдох эрдэмтэн, мэргэжлийн хүмүүсийг хуулийн төсөл боловсруулах ажилд татан оролцуулах хамаарахаар заасан. Мөн тус хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг буюу хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах хэлбэрт холбогдох байгууллагын эрдэмтэн, мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн ажлын хэсэг байгуулж ажиллуулах тухай заасан.

Эдгээр зохицуулалтын дагуу шүүгчид хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүнээр ажиллаж буй практик байна. Тухайлбал, Улсын дээд шүүхийн шүүгч Монгол Улсын Их Хурлын даргын 2015 оны гуравдугаар сарын 04-ний өдрийн 53 дугаар захирамжаар байгуулагдсан Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/, Зөрчлийн тухай хуулийн төслүүд болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн хуралдаанд оролцжээ.²

Мөн дээрх хуулиудад зааснаар хууль санаачлагч хуулийн төсөл буюу хууль тогтоомжийн төсөл боловсруулахтай холбогдон гарах зардлыг өөрийн төсвөөс санхүүжүүлнэ.³ Эндээс дараах асуудал урган гарч байна. Үүнд:

- Хууль санаачлагч болох Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын хувьд шүүгчийг хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүнээр ажиллуулах, холбогдон гарах зардлыг санхүүжүүлэх нь

¹ Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн судлаач-багш, хуульч Л.Галбаатар бэлтгэв.

² Хууль зүйн Байнгын хорооны Ажлын хэсэг хуралдлаа 2015.06.15 <http://www.ikon.mn/n/hp2>; ХЗБХ /Даваа гараг 2016.08.29/ Хуралдааны тэмдэглэл <http://www.parliament.mn/n/ahjo>

³ Хууль тогтоомжийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1

Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.

“шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй” гэх Үндсэн хуулийн зохицуулалттай зөрчилдөх эсэх;⁴

- Шүүгчийн зүгээс төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүнээр ажиллах нь “шүүгч багшлах болон эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэхээс бусад хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсрахыг хориглоно” гэх Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн зохицуулалттай зөрчилдөх эсэх.⁵

Иймд энэхүү лавлагаагаар цаашид шүүгчийг хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт ажиллуулах нь зохимжтой эсэх талаар олон улсын туршлагад тулгуурлан шинжлэн судлав.

Хоёр. Шүүгчийг хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт ажиллуулах асуудлаарх олон улсын туршлага

2.1. Шүүгчдийн статутын тухай 1998 оны Европын дүрмийн зохицуулалт

Шүүгчдийн статутын тухай 1998 оны Европын дүрэмд шүүгчийн шүүн таслах үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагаанд оролцохтой холбоотой асуудлыг тусгасан байна.⁶

Тодруулбал, тус дүрмийн 4.2-т зааснаар шүүгчид албан үүргээс гаднах бусад үйл ажиллагаанд иргэний адил чөлөөтэй оролцож болно. Энэхүү эрх чөлөөг шүүгчийн хараат бус байдалд сөргөөр нөлөөлөхөөс бусад тохиолдолд хязгаарлахгүй. Шүүгчийн албан үүргээс гаднах үйл ажиллагаанд нь цалин хөлс өгдөг бол хууль тогтоомжоор тогтоосон нөхцөлийн дагуу урьдчилан зөвшөөрөл авах ёстой.

2.2. Европын шүүгчдийн зөвлөлдөх зөвлөлийн 2015 оны 18 дугаар зөвлөмж

Европын шүүгчдийн зөвлөлдөх зөвлөлийн 2015 оны “Орчин үеийн ардчилсан нийгэм дэх шүүхийн байр суурь ба түүний төрийн бусад бүрэн эрх мэдэлтэй холбогдох харилцаа” сэдэвт 18 дугаар зөвлөмжид шүүгчийн шүүн таслах үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагаанд оролцохтой холбоотой асуудлыг тусгасан байна.⁷

⁴ Үндсэн хууль. 49.2. Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй.

⁵ Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль. 27.1.15.шүүгч багшлах болон эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэхээс бусад хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсрахыг шүүгчид хориглоно.

⁶ European Charter on the statute for judges (8-10 July 1998) and Explanatory Memorandum to the European Charter on the statute for judges (8- 10 July 1998)

⁷ Consultative Council of European Judges (CCJE) Opinion No. 18 (2015) "The position of the judiciary and its relation with the other powers of state in a modern democracy".

Тодруулбал, тус зөвлөмжийн “Төрийн бусад эрх мэдэлтэй хэлэлцэх нь” гэх 31 дүгээр хэсэгт төрийн гурван эрх мэдлийн байгууллага бүр бусад хоёр эрх мэдлийн байгууллагын ажлын үр дүнгээс хамааралтай гэжээ. Үүнтэй холбоотойгоор эрх мэдэл бүр бусад эрх мэдлийн байгууллагатай түүний үр нөлөөг дээшлүүлэх асуудлаар хамтран ажиллах буюу тийнхүү хэлэлцэх нь зохистой гэжээ. Энэ хүрээнд үндэсний шүүхийн бодлогын асуудлаарх мэтгэлцээнд шүүгчид оролцох нь чухал болохыг Европын шүүгчдийн зөвлөлдөх зөвлөлөөс онцлон тэмдэглэсэн байна. Түүнчлэн, шүүх эрх мэдлийн байгууллага, шүүгчдийн зүгээс тэдний эрх зүйн байдал, шүүхийн тогтолцооны үйл ажиллагаатай холбоотой аливаа хууль тогтоомжийг бэлтгэх, боловсруулах үйл ажиллагаанд идэвхтэй оролцогч нь байж, зөвлөлдөх ёстой гэжээ.

Энэ нь шүүгчдийн хувьд шүүхийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийн төсөл боловсруулах үйл ажиллагаанд шүүгчдийн төлөөлөл оролцохыг Европын шүүгчдийн зөвлөлдөх зөвлөлийн зүгээс дэмжсэн болохыг харуулж байна.

Дүгнэлт

Шүүгчид хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт гишүүнээр ажиллаж буй нь Хууль тогтоомжийн тухай хууль болон түүний өмнө нь үйлчилж байсан Хууль, улсын их хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуульд “Хууль санаачлагч салбар хоорондын уялдааг хангах зорилгоор холбогдох байгууллагын удирдлагатай тохиролцож, тухайн асуудлыг хариуцсан мэргэжилтнийг хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажилд оролцуулж болно”, “Хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулахад холбогдох байгууллагын эрдэмтэн, мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн ажлын хэсэг байгуулж ажиллуулах” тухай заасантай холбоотой байна.

Шүүгчийн эрх зүйн байдал, шүүх эрх мэдлийн бие даасан байдлын асуудлаарх олон улсын байгууллагуудын зөвлөмжид шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд хохирол учруулахгүйгээр шүүхийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийн төсөл боловсруулах үйл ажиллагаанд шүүгчдийн төлөөлөл оролцохыг дэмжих хандлагатай байна.

Иймд шүүгчийг хууль тогтоомжийн төсөл боловсруулах үйл ажиллагаанд оролцуулах буюу тийм чиг үүрэгтэй ажлын хэсгийн гишүүнээр ажиллахыг хориглох нь зохимжгүй байна.

Харин тийнхүү шүүгчийг ажлын хэсэгт ажиллуулахад урьдчилан тогтоосон нөхцөлийн дагуу урьдчилан зөвшөөрөл өгөх буюу шүүгч зөвшөөрөл авах зохицуулалттай байх хэрэгтэй байна. Энэхүү зөвшөөрөл нь тухайн хууль тогтоомжийн төсөл нь шүүхийн үйл ажиллагаатай шууд холбоотой эсэх, шүүгчийн албан үүрэгт сөргөөр нөлөөлөх эсэхийг хянахад чиглэсэн бүртгэлийн

[https://wcd.coe.int/ViewDoc.jsp?p=&Ref=CCJE\(2015\)4&Language=lanEnglish&Ver=original&BackColorInternet=DBDCF2&BackColorIntranet=FDC864&BackColorLogged=FDC864&direct=true](https://wcd.coe.int/ViewDoc.jsp?p=&Ref=CCJE(2015)4&Language=lanEnglish&Ver=original&BackColorInternet=DBDCF2&BackColorIntranet=FDC864&BackColorLogged=FDC864&direct=true)

зохицуулалт байх нь зүйтэй байна. Шүүгчийг хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүнээр ажиллах зөвшөөрлийг тухайн шүүхийн ерөнхий шүүгч буюу шүүгчдийн зөвлөгөөнөөс өгөх нь оновчтой байна.

Ном зүй

- Монгол Улсын Үндсэн хууль. “Төрийн мэдээлэл” 1992 он, №1
- Хууль, улсын их хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хууль. “Төрийн мэдээлэл” 2001 он, №46
- Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль. “Төрийн мэдээлэл”, 2012 он, №11
- Хууль тогтоомжийн тухай хууль. “Төрийн мэдээлэл” 2015 он, №25
- Хууль зүйн байнгын хорооны хуралдаан, ажлын хэсэг хурлын тэмдэглэл, 2015.06.15, 2016.08.29
- European Charter on the statute for judges (8-10 July 1998) and Explanatory Memorandum to the European Charter on the statute for judges (8- 10 July 1998)
- Consultative Council of European Judges (CCJE) Opinion No. 18 (2015) "The position of the judiciary and its relation with the other powers of state in a modern democracy".

